

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
... оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

“УУРХАЙ, УУЛЫН БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ”

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх хэсэг болон холбогдох бусад хууль, дүрэм, журам, заавар, стандартын шаардлага, орд газрыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ зэрэгт үндэслэн хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай техник, технологийг ашиглаж, ил тод, хариуцлагатай уул уурхайн зарчимд нийцүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэл ажлаа хангасан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авахад оршино.

1.2. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын өмнөх бэлтгэл ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэсэн болон шаардлагатай бичиг баримтыг холбогдох төрийн байгууллагаар хянан шийдвэрлүүлж, шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллага (цаашид "компани" гэх) болон Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах комисс (цаашид "Улсын комисс" гэх)-ын төслийн талбайд газар дээр нь болон цахимаар ажиллахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3. Улсын комиссыг дараах тохиолдолд ажиллуулна. Үүнд:

- 1.3.1. шинээр уурхай байгуулах;
- 1.3.2. шинээр баяжуулах үйлдвэр байгуулах;
- 1.3.3. шинээр уурхай, баяжуулах үйлдвэрийн цогцолбор ажиллуулж эхлэх;
- 1.3.4. уурхайн ашиглалтын арга, үндсэн технологит өөрчлөлт орох;
- 1.3.5. түр хаагдсан уурхайг дахин ашиглалтад оруулах.

1.4. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг түшиглэн барьж байгуулсан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрт Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилсон Улсын комисс ажиллаж, холбогдох шийдвэрийг гаргана.

1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад бүх төрлийн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрт Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргын баталсан тушаал, удирдамжийн дагуу Улсын комисс ажиллаж, холбогдох шийдвэрийг гаргана.

Хоёр. Улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлтгэх

2.1. Компани нь Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл хангагдсан үед Улсын комисс ажиллуулах хүсэлтийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр гаргана.

2.2. Улсын комисст хүлээлгэн өгөхийн өмнө компани нь дараах бэлтгэл ажлыг хангасан байна. Үүнд:

2.2.1. уурхайн үйл ажиллагаанд шаардагдах бичиг баримтын бүрдлийг холбогдох эрх зүйн актуудад нийцүүлэн хангах;

2.2.2. уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан уулын ажлын төлөвлөгөөг батлуулж, түүний дагуу уурхайн барилга, байгууламжийн болон шаардлагатай бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

2.2.2.1. уурхайн үйл ажиллагаанд шаардагдах үндсэн, туслах барилга байгууламжууд (уурхайн захиргаа, засварын газар, авто гарааж, тэсрэх материалын агуулах, сэлбэг хэрэгслийн болон түүхий эд, бүтээгдэхүүний агуулах, баяжуулах үйлдвэрийн барилга, технологийн усан сан, хаягдлын далан), тэдгээрт шаардагдах дэд бүтэц (эрчим хүчний эх үүсвэр гадаад, дотоод тээврийн замын сүлжээ болон түүний тэмдэг, тэмдэглэгээ, далан, шуудуу, хэрэглээний усан хангамжийн эх үүсвэр, хадгалах сав, түгээх сүлжээ, гамшиг болон ослоос авран хамгаалах систем, харилцаа холбоо), нийгэм ахуйн байгууламжууд (ажиллагсдын амрах байр, хоолны газар, халуун ус, угаалга, нийтийн бие засах газар, эмнэлгийн тусламж үзүүлэх хэсэг)-ыг холбогдох стандарт, норм, дүрэм, зааврын дагуу барьж байгуулах, шаардлагатай барилга байгууламжуудыг техникийн болон холбогдох Улсын комисст хүлээлгэн өгсөн байх;

2.2.2.2. техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан төслийн хүчин чадлыг хангахуйц техник, тоног төхөөрөмжийн иж бүрдлийг уурхайн талбайд угсарч суурилуулан туршилт тохируулгыг хийж хэвийн ажиллагаанд бэлтгэх;

2.2.2.3. уурхай болон бусад холбогдох объектуудын тухайн ажлын байр бүрд тохирох мэргэжил, мэдлэг, боловсрол, ур чадвар, дадлага бүхий ажиллах ажилтнууд (компанийн үндсэн болон гэрээт туслан гүйцэтгэгч)-ыг авч тэдгээртэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, аюулгүй ажиллагааны дүрэм, журмын дагуу сургалтад хамруулан анхан шатны, ажлын байрны болон давтан зааварчилгааг тогтмол өгч хэвшүүлсэн байх, ажлын байрны нөхцөлд тохирох ажилтан нэг бүрийг хувийн хамгаалах хэрэгслээр хангасан байх;

2.2.2.4. уурхайг ашиглалтад бэлтгэж байгаа бол нээгч малталтуудыг нэвтэрч, хөрс хуулалтыг хийж, олборлолтод бүрэн бэлтгэсэн байх;

2.2.2.5. ашигт малтмал олборлон баяжуулах бол баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийг бүрэн барьж дуусгаж, техник, эдийн засгийн үндэслэлээр сонгосон технологийн схемийн дагуу тоног төхөөрөмжүүдийг угсран химийн бодис, урвалжуудын зарцуулалт, бүтээгдэхүүний гарцыг тодорхойлох хагас үйлдвэрлэлийн туршилтыг хийсэн байх;

2.2.2.6. үйлдвэрлэлийн үндсэн болон туслах процесс (өрөмдлөг, тэсэлгээ, хөрс хуулалт, олборлолт, тээвэр), ажил үйлчилгээ үзүүлэх туслан гүйцэтгэгч (харуул хамгаалалт, ажилчдын амрах байр болон бусад сервис үйлчилгээ), ханган нийлүүлэгч хуулийн этгээдтэй хамтран ажиллах гэрээг байгуулах, тэдгээрийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтын бүрдлийг хангасан байх;

2.2.2.7. уурхайн үйлдвэрлэлийн үндсэн болон туслах үйл ажиллагаанд шаардагдах газар эзэмших, ашиглах гэрээ, ус ашиглах гэрээ, орон нутагтай хамтран ажиллах гэрээ, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын зардлыг нөхөн төлөх тухай гэрээ зэргийг холбогдох төрийн байгууллагуудтай байгуулсан байх.

2.3. Улсын комисс уурхай, уулын үйлдвэрт цахимаар ажиллах тохиолдолд компани нь дараах бэлтгэл ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

2.3.1. энэхүү журмын 2.2-т заасан бүрдлийг хангасан байх;

2.3.2. компани нь Улсын комиссыг төслийг талбай, холбогдох байгууламжтай цахимаар танилцах боломжийг бүрдүүлсэн байх;

2.3.3. дроноор болон камераар хийсэн бичлэг нь техникийн шаардлага хангасан, тайлбартай байх.

Гурав.Улсын комиссын зохион байгуулалт, бүрэлдэхүүн

3.1. Улсын комиссын бүрэлдэхүүнийг энэхүү журмын 1.5.-д заасан тушаалыг үндэслэн Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан хариуцсан нэгжийн даргын тухай бүр баталсан удирдамжаар томилно.

3.2. Энэхүү журмын 3.1-т заасан бүрэлдэхүүнийг Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгжийн дарга, ахлах шинжээчээр ахлуулах ба Улсын комиссын нарийн бичгийн дарга нь тус нэгжийн тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

3.3. Улсын комиссын нарийн бичгийн дарга нь компанийн ирүүлсэн албан хүсэлтийг хүлээн авч уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хэрхэн хангасан талаар энэхүү журмын 2.2.1-д заасан бичиг баримтын бүрдэл хангагдсан эсэхтэй танилцаад Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан нэгжийн даргад танилцуулж, улмаар Улсын комиссыг ажиллуулах эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

3.4. Энэхүү журмын 2.2.1 дэх заалт хангагдсан тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгжийн дарга Улсын комиссын бүрэлдэхүүн, түүний ажиллах удирдамжийг энэхүү журмын 3.1-д зааснаар батална.

3.5. Энэхүү журмын 3.1-д заасан Улсын комиссын бүрэлдэхүүнд дараах төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулна. Үүнд:

3.5.1. геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.5.2. геологи, уул уурхайн асуудлаар хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага;

3.5.3. байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.5.4. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.5.5. геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

3.6. Энэхүү журмын 3.5-д дурдсан байгууллагууд нь Улсын комиссын бүрэлдэхүүнд өөрийн байгууллагын бүтцэд шууд харьяалах тухайн төсөл хэрэгжүүлэх газар нутагт байрлах бүс, нутгийг хариуцсан салбар нэгж болон төлөөлөгчийн газраас төлөөлөл томилон ажиллуулж болно.

3.7. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн зарим тусгай технологи, мэргэжлийн нарийн онцлог шаардсан үйлдвэрт Улсын комисс томилох тохиолдолд Улсын комиссын даргын санал болгосноор холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг харилцан тохиролцсоны үндсэн дээр оролцуулж болно. Үүнд:

3.7.1. эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.7.2. барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.7.3. замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

3.7.4. нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар;

3.7.5. онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага /Уул уурхайн аврах алба/;

3.7.6. гаалийн ерөнхий газар;

3.7.7. стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн байгууллага;

3.7.8. хил хамгаалах байгууллага;

3.8. Улсын комиссын нарийн бичгийн дарга нь Улсын комиссын дарга, гишүүдээр "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай" мэдэгдлийн хуудсыг бөглүүлж, холбогдох шийдвэрийн хамт хадгална.

Дөрөв.Улсын комиссын үйл ажиллагаа

4.1. Улсын комиссын бүрэлдэхүүн томилогдож бэлтгэл ажил хангагдсан тохиолдолд Улсын комиссын нарийн бичгийн дарга компанитай Улсын комиссыг ажиллуулах хугацааг тохирон гишүүдэд урьдчилан мэдэгдэнэ.

4.2. Компани нь Улсын комиссыг төвлөсөн хугацаанд уурхайд хүргэх, ажиллах хугацаанд шаардлагатай бичиг баримт, техник хэрэгслээр хангах ажиллагааг Улсын комиссын нарийн бичгийн даргатай хамтран зохион байгуулна.

4.3. Улсын комисс уурхайд ажиллах хугацаанд компани нь өөрийн болон туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчдийн бичиг баримт, тоног төхөөрөмж, ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг байлцуулж, үйл ажиллагааны талаар холбогдох тайлбар тодруулга өгнө.

4.4. Улсын комисс уурхайд ажиллахдаа уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлүүлэх, бэлтгэл ажил хангагдсан байдал, үндсэн болон туслах объектууд, тэдгээрийн дэд бүтэц, нийгэм ахуйн байгууламжууд, тоног төхөөрөмж, ажиллах хүчин болон бусад холбогдох бичиг баримтууд, дагалдах эрх, зөвшөөрлүүдийн бүрдэл, дүрэм, заавар, журам, норм, стандартын хэм хэмжээ зэрэг бүх талаар уурхайг хүлээн авах нөхцөл хангагдсан зэргийг нягтлан танилцана.

4.5. Компани нь Улсын комиссын гишүүдийн асуусан асуулт, тодруулга, лавлагаанд тухай бүрд нь хариулт өгч шаардсан мэдээ, мэдээлэл, материалыг гарган өгч танилцуулна.

4.6. Улсын комисс үзлэг, шалгалтыг хийж дуусгаснаар компанийн болон туслан гүйцэтгэгч компанийн удирдлагын төлөөллийг байлцуулан хуралдана.

4.7. Хуралдаанаар гишүүн бүр өөрийн ажил үүргийн холбоотой үзэж, шалгасан асуудлуудынхаа талаарх дүгнэлт, зөвлөмж, зөвлөгөөг хуралд оролцогчдод танилцуулж, уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах эсэх саналаа гаргана.

4.8. Улсын комиссын гишүүдийн олонхын саналаар уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.

4.9. Улсын комиссын хуралдаанаар дараах төрлийн шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

4.9.1. Улсын комисс хуралдсан өдрөөр хүлээн авсан тухай шийдвэр бүхий "Улсын комиссын акт" гаргаж бүх гишүүд гарын үсэг зурж албажуулна. Ингэхдээ гишүүдийн саналд тулгуурлан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн

цаашдын үйл ажиллагаанд анхаарч ажиллах шаардлагатай зүйлсийг зөвлөмж болгон актад тусгаж болно.

4.9.2. Улсын комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавруудын биелэлтийг нь эргэж тайлагнах, боломжтой бол биелүүлэх хугацааг тодорхой заасан "Улсын комиссын албан даалгаврын хуудас"-ыг гаргана. "Улсын комиссын албан даалгаврын хуудас"-т заагдсан үүрэг даалгаврууд биелэгдэж, даалгаврын биелэлт хангагдсан тохиолдолд уурхайг хүлээн авсанд тооцох ба "Улсын комиссын акт"-ыг үйлдэж бүх гишүүд гарын үсэг зурж албажуулна.

4.9.3. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авахаас татгалзаж, шалтгааныг тодорхой заасан "Улсын комиссын хуралдааны тэмдэглэл"-ийг бүх гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулан компанид хүлээлгэн өгнө. Энэ тохиолдолд татгалзсан тодорхой нөхцөл байдал арилах эсхүл эрх зүйн актуудаар хүлээсэн үүрэг даалгаврын шаардлага хангагдах боломжтой болсон үед Улсын комиссыг дахин ажиллуулах хүсэлтийг гаргах эрхтэй талаар заавал дурдана.

4.10. Улсын комиссын акт нь бүх гишүүдийн гарын үсэг зурагдаж, хүчин төгөлдөр болсон өдрөөр уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авсан гэж үзэх ба тухайн өдрөөс бүтээгдэхүүн борлуулах эрх нээгдсэнд тооцно.

4.11. Улсын комиссын хуралдаанаар гаргасан дүгнэлттэй зарчмын зөрүүтэй саналтай гишүүд өөрийн саналаа хурлын тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлж болно.

4.12. Улсын комисс нь хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

4.13. Улсын комиссын нарийн бичгийн дарга аливаа шийдвэрийг Улсын комиссын хэвлэмэл хуудсанд хэвлэн, Улсын комиссын тэмдгийг дарж баталгаажуулна.

4.14. Улсын комиссын нарийн бичгийн дарга "Улсын комиссын акт"-ыг 3 хувь үйлдэж Улсын комиссын тэмдгийг дарж баталгаажуулж нэг хувийг компанид, нэг хувийг өөрийн байгууллагын албан хэрэгцээнд ашиглах ба нэг хувийг Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Уул уурхайн хэлтэст хүргүүлнэ.

4.15. Улсын комисс ажилласан тайланг ажлын 5 хоногийн дотор гаргаж Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргад танилцуулна.

Тав. Компанийн эрх, үүрэг

5.1. Компани нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээлгэн өгөх хүсэлтээ Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр хүргүүлэх ба энэхүү журмын 2.2-т заасан бэлтгэл ажлыг хангасан байна.

5.2. Компани нь Улсын комиссын нарийн бичгийн даргад энэхүү журмын хавсралтад заасан бүрдлийг Улсын комисс ажиллахаас ажлын 10 хоногийн өмнө урьдчилж хянуулсан байна.

5.3. Компани нь Улсын комиссын ирэх, буцах болон тухайн уурхай, үйлдвэрт ажиллах үеийн аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

5.4. Улсын комиссын төслийн талбайд газар дээр нь ажиллах албан хаагчийн томилолтын зардлыг Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.9 дэх хэсэгт */Байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтээр албан томилолтоор ажиллах*

тохиолдолд харилцан тохиролцсоны үндсэн дээр албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж хариуцаж болно/ заасны дагуу компани хариуцаж, Сангийн сайдын 2022 оны 120 дугаар “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу томилолтын зардлыг тооцно.

5.5. Томилолтын зардлыг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэмэлт санхүүжилтийн төрийн сангийн дансанд байршуулна.

5.6. Улсын комисс цахимаар ажиллах үед Улсын комиссын гишүүдэд албан томилолтын зардал олгохгүй.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү журам болон Улсын комисс, түүний гишүүдийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн аливаа гомдлыг Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болох ба түүнээс гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд холбогдох шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----oOo----

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
... оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг
хүлээн авахад шаардлагатай бичиг баримтын
бүрдлийн жагсаалт**

1. Ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэл
2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
3. Тухайн жилийн батлагдсан уулын ажлын төлөвлөгөө
4. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ
5. Олборлолтын журнал (ашиглалтын үеийн геологи, маркшейдерийн хэмжилт, сар, улирлын гүйцэтгэлийн мэдээ гэх мэт)
6. Төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын зардлыг нөхөн төлөх гэрээ, төлбөрийн баримт
7. Технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын тайлан, баяжуулалтын алдагдал хаягдлыг өөрсдөө болон хяналтын байгууллагын тогтоосон тайлан, хяналтын байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
8. Уурхайн эдэлбэрийн шав тавиулсан тухай акт
9. Тэсэлгээний ажил явуулах зөвшөөрөл (Өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт)
10. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн менежментийн төлөвлөгөө
11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын 50%-ийг барьцаалсан баримт
12. Газар, ус ашиглах гэрээ болон төлбөр төлсөн тухай баримт
13. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа
14. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
15. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтын бүртгэл
16. Ажиллах хүчний судалгаа, тэдгээртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ (тухайн орон нутгаас ажиллаж буй ажилчдын ажлын байрны судалгаа)

----oOo----

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
... оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**Баяжуулах үйлдвэрийг хүлээн авахад
оруулахад шаардлагатай бичиг
баримтын бүрдлийн жагсаалт**

1. Баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл
2. Тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө
3. Баяжуулах үйлдвэрийн баталгаажуулсан зураг төсөл
4. Үйлдвэрийн барилга байгууламжийг Улсын комисст хүлээлгэн өгсөн акт
5. Хаягдлын аж ахуйн далангийн баталгаажуулсан зураг төсөл
6. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн журнал (сар, улирлын гүйцэтгэл)
7. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
8. Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээ
9. Технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтын тайлан, баяжуулалтын алдагдал хаягдлыг өөрсдөө болон хяналтын байгууллагын тогтоосон тайлан, хяналтын байгууллагын өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
10. Байгаль орчныг хамгаалах тухайн жилийн менежментийн төлөвлөгөө
11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын 50%-ийг барьцаалсан баримт
12. Газар, ус ашиглах гэрээ болон төлбөр төлсөн тухай баримт
13. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа
14. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
15. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, сургалтын бүртгэл
16. Ажиллах хүчний судалгаа, тэдгээртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ (тухайн орон нутгаас ажиллаж буй ажилчдын ажлын байрны судалгаа)
17. Ашигт малтмалын хүдэр, баяжмал худалдан авах гэрээ

----oOo----

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
... оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ УЛСЫН КОМИССЫН АКТ

*“.....” ХХК-ийн эзэмшиж
буй тоот ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй “.....” нэртэй
ашиглалтад хүлээн авах тухай*

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Уурхай, уулын үйлдвэрийн нэр, байршил, хүчин чадал, ашигт малтмалын төрөл, хөрөнгө оруулалт, ажиллагсдын тоо:
- 1.2. Эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж:
- 1.3. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр:
- 1.4. Туслан гүйцэтгэгч:
- 1.5. Удирдамж:

ХОЁР. ШИЙДВЭР

- 2.1.
- 2.1.1.
- 2.1.2.
- 2.2.

ГУРАВ. УЛСЫН КОМИССЫН ЗӨВЛӨМЖ

- 3.1.

ДӨРӨВ. УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Дарга:
Нарийн бичгийн дарга:
Гишүүд:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
... оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар тушаалын 5 дугаар хавсралт

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
УЛСЫН КОМИССЫН ТЭМДЭГЛЭЛ**

“.....” ХХК-ийн эзэмшиж
буй тоот ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй “.....” нэртэй
ашиглалтад хүлээн авах тухай

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

.....
ХОЁР. УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Комиссын нарийн бичгийн дарга:

Комиссын гишүүд:.....

ГУРАВ. АЖ АХУЙН НЭГЖИЙН БҮРЭЛДЭХҮҮН

.....
ДӨРӨВ. ХЭЛЭЛЦСЭН НЬ:

.....
ТАВ. САНАЛ

.....
ЗУРГАА. ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

.....
ДОЛОО. ХОЁР. УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

.....

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
... оны ... дугаар сарын ... –ны өдрийн
... дугаар тушаалын 6 дугаар хавсралт

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
УЛСЫН КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР**

*“.....” ХХК-ийн эзэмшиж
буй тоот ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй “.....” нэртэй
ашиглалтад хүлээн авах тухай*

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

.....

ХОЁР. АЛБАН ДААЛГАВАР

2.1.

.....

ГУРАВ. ХОЁР. УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

.....